



**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/48

Улаанбаатар хот

「 Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын ээлжит V хуралдааныг зарлан
хуралдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6, 48 дугаар зүйлийн 48.3, 52 дугаар зүйлийн 52.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит V хуралдааныг 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 09 цагт танхимаар хуралдуулсугай.

2. Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг хавсралтаар баталсугай.

3. Хуралдааныг бэлтгэл ажлын төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, зардлыг Хурлын зохих төсвөөс гарган, хуралдаанаас гарах шийдвэрийг холбогдох газруудад хүргүүлэн ажиллахыг Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Байгаль)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ч.БАТ-ОРГИЛ

Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын даргын 2025 оны 06 дугаар сарын
13-ны өдрийн 478 дугаар захирамжийн
хавсралт



ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
V ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1. Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Эмэгтэйчүүдийн зөвлөл байгуулах тухай
Танилцуулагч: Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Байгаль
2. "Хан-Уул дүүргийн теле камерийн хяналтын дэд төв" орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар байгуулах тухай
3. Тодорхойлолтыг дэмжих тухай
Танилцуулагч: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга З.Буянт
4. Хороодын хамтарсан багийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай
Танилцуулагч: Дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн дарга М.Ганболд